



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 13

Улаанбаатар

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-иас ирүүлсэн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 219 дугаар “Хөрөнгө үнэлсэн тухай” тайлан, дүгнэлттэй танилцаж, Компанийн хөрөнгийн үнэлгээг зөвшөөрсөн болохыг дурдсугай.
2. Компанийн Хөрөнгийн үнэлгээний тайланг “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу Хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Чулуунтогтох/-д итгэмжлэн даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 14

Улаанбаатар

КОМПАНИЙН ЭД ХӨРӨНГӨ, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ ТОГТООЖ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, 54 дүгээр зүйл, 55 дугаар зүйлийн 55.2, 55.6 хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах нэг бүрийн үнийг 18,000 /арван найман мянган/ төгрөг байхаар тогтоосугай.
2. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах журам”-ыг Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гаргасан тогтоолыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ХК-д хүргүүлэх, бусад шаардлагатай ажиллагааг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Чулуунтогтох/-д итгэмжилсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА

100000
ТТБ-3001
УЛААНБААТАР ХОТ

Л.БУЯНБАТ



КОМПАНИ ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү “Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах журам” /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь Тахько (ХК) компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах асуудалд эсрэг саналтай байсан болон санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг компани эргүүлэн худалдан авах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журамд заасны дагуу Компани нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардах эрх үүссэн өдөр компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн гаргана.
- 1.3. Хувьцаа эзэмшигч нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу цахим хэлбэрээр мэдэгдэл авснаас хойш ажлын 30 өдрийн дотор Тахько (ХК) компанид өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авах тухай шаардлагыг хүргүүлнэ.
- 1.4. Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй Хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.
- 1.5. Цахим хэлбэрээр шаардлага гаргах тохиолдолд Компанийн takhicotuz@gmail.com цахим хаягт хүргүүлэх ба бичгээр шаардлага гаргахдаа Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Ж.Самбуугийн гудамж, Тахько (ХК) компанийн төв оффист хүргүүлэх бөгөөд хүсэлтэд дор дурдсан мэдээллийг заавал оруулсан байна. Үүнд:
 - Овог, нэр
 - Оршин суугаа газрын хаяг
 - Холбоо барих утасны дугаар /2-оос дээш/
 - Регистрийн дугаар болон Иргэний бүртгэлийн дугаар
 - Эргүүлэн худалдаж авахыг шаардаж буй хувьцааны тоо
- 1.6. Компани нь Хувьцаа эзэмшигчийн ирүүлсэн шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор эргүүлэн худалдаж авах эрхийн тухай мэдээлсэн мэдэгдэл дурдсан зах зээлийн үнээр хувьцааг худалдан авах, эсхүл Хувьцаа эзэмшигчийн хувьцааг эргүүлэн худалдаж авахаас татгалзсан үндэслэлээ Хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 1.7. Хувьцаа эзэмшигчдийн шаардлагын дагуу компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаа хэрэгжиж буйтай холбогдуулан компанийн хувьцааны арилжааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түр зогсоож болно.
- 1.8. Хувьцаагаа эргүүлэн худалдан авах тухай Хувьцаа эзэмшигчийн шаардлагыг Төлөөлөн удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх захирал хүлээн авч тухай бүр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад мэдэгдэж ажиллах үүрэгтэй бөгөөд Гүйцэтгэх захирал нь Хувьцаа эзэмшигчтэй “Хувьцаа эргүүлэн худалдан авах гэрээ” байгуулж, тус гэрээг Монголын Хөрөнгийн Биржид хууль, тогтоомжид заасан хугацаанд бүртгүүлж, хэрэгжилтийг ханган ажиллана.
- 1.9. Хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардаагүй, компанид Хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт гаргаагүй Хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн Хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлнэ.



Хоёр. Шаардах эрхээ хэрэгжүүлж буй хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй энгийн Хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.
- 2.2. Компаниас “Хувьцаа эргүүлэн худалдан авах гэрээ” байгуулахыг шаардах эрхтэй.
- 2.3. Хувьцаагаа эргүүлэн авахыг шаардсан Хувьцаа эзэмшигч нь өөрийн шаардлагадаа энэхүү журмын 1.5 дахь хэсэгт заасан мэдээллийг бүрэн оруулах үүрэгтэй.
- 2.4. Хувьцаа эзэмшигч нь энэхүү журмын 1.3 дахь хэсэгт заасан хугацаанд шаардах эрхээ хэрэгжүүлээгүй буюу шаардлага гаргаагүй бол гомдол гаргах эрхгүй байна.
- 2.5. Хувьцаа эзэмшигч нь Компанид хувьцаа худалдах тухай шаардлагыг бичгээр болон цахим хэлбэрээр гаргахдаа холбогдох мэдээллийг үнэн зөв гаргах үүрэгтэй ба шаардлагад худал мэдээлэл оруулсантай холбогдуулан гарах үр дагаврыг Компани хариуцахгүй болно.

Гурав. Компанийн эрх, үүрэг

- 3.1. Компаниас шаардах эрх үүссэн талаарх шийдвэрийг холбогдох журмын дагуу өдөр тутам хэвлэгдэн гардаг сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, мөн Компанийн өөрийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар тус бүр хоёроос доошгүй удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 3.2. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн хувийн мэдээллийг хамгаалж, бусдад задруулахгүй байх үүрэгтэй.
- 3.3. Компани нь энэхүү журмын 1.3 дахь хэсэгт заасан хугацаанд Компанид хүргүүлсэн Хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэн хариу хүргүүлэн ажиллах үүрэгтэй.

Дөрөв. Бусад зүйл

- 4.1. Энэхүү журмыг Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлнэ.
- 4.2. Энэхүү журам нь Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

-----ooOoo-----

